Байгууллагын нэр: “Улаанбаатар лифт” НӨҮГ

# НИЙСЛЭЛИЙН ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ДЭД ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2023 оны 06 дугаар сарын 28 Улаанбаатар хот

**Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, зорилт:** Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 36 дугаар тогтоол “Нийслэлийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр”

**Зорилт 1:** Нийслэлийн хөгжлийн эрх зүйн орчин, бодлого төлөвлөлт, төсөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах үзэл баримтлал, арга зүйг нэвтрүүлж, бүх шатны төрийн төрийн албан хаагчдыг чадавхижуулах

| № | Үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэтгэл, хувь | Дэлгэрэнгүй тайлбар /Хэрэгжээгүй шалтгаан/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Он | Түвшин | | | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1 | 1.1 Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагуудад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, эрх зүйн актуудад хийсэн жендэрийн нөлөөллийн үнэлгээний үр дүн, аргачлалыг нийслэлийн өөрөө удирдах, захиргааны байгууллагын удирдлага, төрийн албан хаагчдад танилцуулах, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна. | Жил бүрийн нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлага, төрийн албан хаагчдад зориулсан сургалт мэдээллийг 2-оос доошгүй удаа зохион байгуулна. | 2023 | 1 | 2 | 1 | 100% | |
| 2 | 1.2 Тухайн төрийн ба төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж өөрийн ажилчдын хүйсийн тэнцвэрт байдал, | Байгууллагууд ажилтны Ажил-ар гэрийн тэнцвэр хангах чиглэлийн асуудалд жендэрийн үнэлгээ хийж, | 2023 | 80% | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь 100% | Үйл ажиллагааны хэрэгжилт 100% | 80% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлал, бэлгийн дарамттай тэмцэх, ажилтны Ажил-ар гэрийн тэнцвэрт байдалд жендэрийн нөлөөллийн үнэлгээ хийж, бодлого төлөвлөлтөө сайжруулах. | үр дүнг бодлого төлөвлөлтөд тусгасан байна. | | | | | | |
| **Зорилт 1-ийн хэрэгжилт:**<br>1.1.Байгууллагын удирдлага, албан хаагчдад зориулан 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр Кристина Ноблийн хүүхдийн сангаас "Гэр бүлийн сэтгэл зүй"-н сургалт авсан байна.<br>1.2.Ажлын байран дахь хүйсийн ялгаварлал, бэлгийн дарамтыг арилгахад чиглэсэн зохицуулалтыг байгууллагын дотоод журамд нэмж тусгасан. Мөн байгууллагын ажилтны Ажил-ар гэрийн тэнцвэр хангах чиглэлийн асуудалд жендэрийн үнэлгээ хийж, үр дүнг төлөвлөлтөд тусгасан. | | | | | | | | Дундаж гүйцэтгэл, хувь 90% |
| Зорилт 2: Жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан хүчирхийлэл, тэгш бус байдлын үндсэн шалтгаан болсон жендэрийн хэвшмэл үзэл ойлголт буюу сөрөг хандлагыг өөрчлөх цогц стратегийг төрийн албан хаагч, оролцогч талууд, олон нийтийн дунд хэрэгжүүлэх | | | | | | | | |
| 3 | 2.1 Жендэрийн хэвшил ойлголтын сөрөг үр дагавар, ялгаварлан гадуурхалттай тэмцэх талаар олон нийтийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх нөлөөллийн ажлыг тогтмол явуулах | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо: жил бүр 4-өөс доошгүй байна.<br>Хэвлэл мэдээллийн хэрэгслээр жилд 3-аас доошгүй удаа хууль, эрх зүйн мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээсэн байна.<br>Сошиал сүлжээнд жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн тусгай хуудас бий болгосон байна. | 2023 | 100% | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь 100% | Үйл ажиллагааны хэрэгжилт 100% | 100% | |
| 4 | 2.2 Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн төлөвлөгөөг боловсруулж, газрын даргаар батлуулах. | Батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | 2023 | 100% | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь, 100% | Үйл ажиллагааны хэрэгжилт, 100% | 100% | |
| **Зорилт 2-ын хэрэгжилт:**<br>2.1.Байгууллага хамт олноороо Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан "ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЕ" аяныг 2023 оны 03 дугаар сарын 10-23-ны өдрүүдэд "Надаас, Таниас, Биднээс Эхлэлтэй" уриан дор | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах, эмэгтэйчүүдийн нийгэмд үзүүлэх үр нөлөө, эмэгтэйчүүдийн манлайллын талаарх ойлголт мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор дараах нөлөөллийн ажлын уриа, мэдээллийг байгууллагын албан ёсны цахим хуудас, фэйсбүүк хуудсаар олон нийтэд түгээн нийт албан хаагчид хувийн хаягаараа хуваалцаж, түгээж ажилласан.<br>2.2.Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, байгууллагын эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хүүхэд хамгааллын түншлэлийг сайжруулах мөн хүүхдийг орчны эрсдэлт нөхцөлд өртөх, осол гэмтэлд орохоос урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх "Нэгдүгээрт хүүхэд" нэгдсэн аяныг 2023 оны 06 дугаар сарын 19-23-ны өдрүүдийн хооронд нийт 8 ажлыг зохион байгуулж ажилласан. Аяны тайлан мэдээг 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдөр 1dugeerthuuhed@gmail.com хаягаар хүргүүлсэн.<br>- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны харьяа байгууллагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах, хот нийтийн аж ахуйг сурталчлах, хамт олонч уур амьсгалыг бүрдүүлэх, багаар хамтарч ажиллах чадварт сургах, спортын талбарт шударгаар өрсөлдөх, ажилчдын эрүүл мэнд, биеийн хөгжил, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, дархлааг дэмжих зорилгоор "ШИЛЖИН ЯВАХ ЦОМ"-ын төлөө 5 төрөлт тэмцээнд 2023 оны 05 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд оролцсон. | | | | | | | | Дундаж гүйцэтгэл, хувь 100% |
| **Зорилт 3:** Нийслэлийн хүн ам, гэр бүл, охид хөвгүүд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд тулгамдаж буй жендэрийн тэгш бус байдлыг арилгахад чиглэсэн" тусгай арга хэмжээ", бусад төрөл бүрийн үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх | | | | | | | | |
| 5 | 3.1 Төрийг албан хаагчдын Ажил-ар гэрийн тэнцвэр хангах чиглэлд судалгаа хийж, түүнд үндэслэн байгууллагын дэргэд цэцэрлэг байгуулах ойр цэцэрлэгтэй гэрээ байгуулах зэргээр ажилтнуудын хүүхдийн ясли, цэцэрлэгийн асуудлыг үе шаттай шийдвэрлэх | 1-12 дугаар ангийн хүүхэдтэй ажилтанд хүүхэддээ зориулсан цаг гаргадаг болсон байна.<br>Ажилтнуудын илүү цагаар ажилласан байдалд жилд 1 удаа жендэрийн дүн шинжилгээ хийж, түүний мөрөөр арга хэмжээ авсан байна. | 2023 | 100% | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь 100% | Үйл ажиллагааны хэрэгжилт 100% | 100% | |
| **Зорилт 3-ын хэрэгжилт:** 1-12 дугаар ангийн хүүхэдтэй ажилтанд хүүхэддээ зориулсан цаг гаргадаг болгохоор зарим ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Тухайлбал: Ажилтнуудад хүүхдийнх нь төрсөн өдрөөр цалинтай чөлөө олгож байна. Ясли, цэцэрлэг, бага ангийн хүүхдүүдтэй эх, өрх толгойлсон эцэгт хүүхдээ хүргэж өгөх цагийн менежментийг шийдэж, өглөө ажилд ирэх цагийг 8 цаг 30 минут болгож хойшлуулсан ба цайны цагаар 30 минут нөхөж ажилласан. Манай байгууллагын ажилтнууд 2023 оны эхний хагас жилийн байдлаар илүү цагаар ажилласан ажилтан байхгүй байна. Цэцэрлэгийн насны хүүхэд манай байгууллагын хэмжээнд 4 байгаа бөгөөд гэрийнхээ ойр цэцэрлэгт хамрагдсан байна. | | | | | | | | Дундаж гүйцэтгэл, хувь 100% |
| **НИЙТ БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ** | | | | | | | | **97%** |

Жендерийн эрх тэгш байдал, хүүхдийг эрсдэлээс хамгаалах ажлыг олон нийтэд таниулах байдлыг хангаж ажилласан байдал














УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА
УЛААНБААТАР ЛИФТ НӨУГ


УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА
УЛААНБААТАР ЛИФТ НӨУГ








Сэтгэл зүйн дэмжлэг гэдэг нь:
Хүүхдийн сайн талд тулгуурлан өөрийн үнэлгээг дээшлүүлэх
Хүч чадалдаа итгэх итгэл төрүүлэх
Алдаж эндэхээс сэргийлэх боломж олгох
Азгүйтсэн үед нь тусалж дэмжих үйл ажиллагаа мөн




Хүүхэдтэй хэрхэн зөв харилцах вэ?


Улаанбаатар лифт НӨҮГ /Ulaanbaatar lift Capital City owned enterprise/
2өдөр
"ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЕ-2023"
Жендэрийн Үндэсний Хороо
3-р сарын 8 өдрийн 10:58 цаг
Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын хүн амын сангийн дэмжлэгтэйгээр жил бүр зохион байгуулагддаг Жендэрийн үндэсний хорооны "Надаас, танаас, биднээс эхлэлтэй" ури...
Цааш үзэх


#ХАРИЛЦАН_ХҮНДЭТГЭЕ АЯНД НЭГДЛЭЭ.
Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохилдуулан Жендэрийн Үндэсний Хорооны Ажлын албанаас зохион байгуулж буй #ХАРИЛЦАН_ХҮНДЭТГЭЕ аянд нэгдлээ.
#НАДААС_ТАНИАС_БИДНЭЭС_ЭХЛЭЛТЭЙ
Надаас
Танаас
харилцан
хүндэтгэе
Биднээс
Эхлэлтэй


Улаанбаатар лифт НӨҮГ /Ulaanbaatar lift Capital City owned enterprise/
6өдөр
Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр. Монгол цэргийн өдрийг тохилдуулан Жендэрийн Үндэсний Хорооны Ажлын албанаас зохион байгуулж буй #ХАРИЛЦАН_ХҮНДЭТГЭЕ аянд нэгдлээ.
#НАДААС_ТАНИАС_БИДНЭЭС_ЭХЛЭЛТЭЙ
Надаас
Танаас
харилцан
хүндэтгэе
Биднээс
Эхлэлтэй


Надаас
Танаас
харилцан
хүндэтгэе
Биднээс
Эхлэлтэй
" Улаанбаатар лифт" НӨҮГ







ХЯНАСАН:
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР М.ЭНХБАТ

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:
АРХИВ, БИЧИГ ХЭРЭГ, ДОТООД
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Н.НАРАНГУА